ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ
ХУВЬЦААТ КОМПАНИ

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 20 өдөр Дугаар: А/85 Улаанбаатар хот

Авилагт өртөх эрсдэл бүхий
албан тушаалын жагсаалт батлах тухай

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дах заалт, "Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.3.2, 4.3.3, Авилагт өртөх эрсдэл бүхийн албан тушаалын жагсаалтын талаарх нийт ажилтан нараас авсан судалгаа, Захирлуудын зөвлөлийн 2018 оны 11 дугаар сарын 19-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК-ийн Авилагт өртөх эрсдэл бүхий албан тушаалтны жагсаалтыг тушаалын хавсралтаар баталсугай.

2. Авилагт өртөх эрсдэл бүхий албан тушаалтны жагсаалтад орсон ажилтан нарыг аливаа худалдан авах ажиллагаа болон гэрээ, хэлцэл байгуулах, мөнгөн хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохоос өмнө хувийн ашиг сонирхол байгаа эсэх урьдчилсан мэдүүлгийг тухай бүр гаргуулан авахыг Захиргаа, удирдлагын газрын Захиргаа, аж ахуй хариуцсан ажилтан /О.Чинцэцэг/-т даалгасугай.

3. Авилагт өртөх эрсдэл бүхий албан тушаалтны жагсаалтад орсон албан тушаалтан нарын урьдчилсан мэдүүлгийг хадгалах, холбогдох байгууллагад мэдээлэн шилжүүлэх, хууль, тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий хуульч-Эрхий бүхийн албан тушаалтан /Г.Батзаяа/-т даалгасугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч захирал /О.Наранхүү/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ЭНХТАЙВАН

Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ний
Гүйцэтгэх захирлын 2018 оны 11 дүгээр
сарын 20-ний өдрийн А/85 дугаар
тушаалын хавсралт

Авилагт өртөх эрсдэл бүхий
албан тушаалын жагсаалт

| Д/д | Овог, нэр | Албан тушаал | Судалгаа тоо | И-мэйл хаяг |
|---|---|---|---|---|
| 1. | Г.Энхтайван | Гүйцэтгэх захирал | 26 | enkhtaivan@agreinsurance.mn |
| 2. | Д.Дуулал | Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн удирдлагын газрын дарга | 23 | duulal@agreinsurance.mn |
| 3. | О.Наранхүү | Дэд захирал | 22 | narankhuu@agreinsurance.mn |
| 4. | Ч.Соронзонболд | Ерөнхий нягтлан бодогч | 19 | soronzonbold@agreinsurance.mn |
| 5. | Т.Оюунбат | Андеррайтингийн газрын дарга | 18 | t.oyunbat@agreinsurance.mn |